



History of the XX Century Mongolia

**1921 REVOLUTION: 4. BOGD KHAN-HEADED MONGOLIA &
COMMUNIST RUSSIA**

LECTURE 8

LECTURER: PROF. OTGONJARGAL SODNOMDARJAA

NATIONAL UNIVERSITY OF MONGOLIA

XX зууны Монголын Түүх

1921 ОНЫ ХУВЬСГАЛ: 4. БОГД ХААНТ МОНГОЛ УЛС БА
КОММУНИСТ ОРОС


ЛЕКЦ 8

ПРОФ.ОТГОНЖАРГАЛ СОДНОМДАРЖАА
МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ


Лекцийн агуулга

Санаандгүй юм болгон гарцаагүй, гарцаагүй юм болгон санаандгүй. Энэ лекцээр бид мета онолыг ойлгохын дээр метатүүхийн мөн чанарыг ойлгох болно


Мөн үнэн түүхээ мэдэж авна



Социализмын жилүүдэд МАН-ыг 1920 оны 6-р сарын 25-нд байгуулагдсан, Монголд анхны нам үүссэн өдөр хэмээн онцлон тэмдэглэсээр ирсэн. Ингэж ч ярих, бичихийг шаарддаг байв.



1920 оны 6-р сарын 25-нд Ноёдын нам, Түшмэдийн намын хамтарсан нууц зөвлөгөөн болж ЗОУ-аас хааны тамгатай бичгээр тусламж гуйх, төлөөлөгчдийг томилох зэрэг асуудлыг хэлэлцсэн байна.



1920 оны 6 сарын 25-нд болсон Ноёдын нам, Түшмэдийн намын хамтарсан хуралдаанаар С.Данзан, Д.Бодоо, Д.Чагдаржав, Д.Сүхбаатар, Д.Догсом, Д.Лосол, Х.Чойбалсан нарыг Орос улсад томилохоор хэлэлцэн тохиров.

ЗОУ-аас тусламж хүсэхээр Богд хаанаас
томилогдсон “Түшмэдийн нам”-ын гишүүд




<https://www.gereg.mn>

Хувьсгалын 7 гэж алдаршсан
Түшмэдийн Намынхан

ЗОУ-аас тусламж хүссэн бичгийн монгол эхийн ноорог

Орос улсаас
тусламж хүсэх
бичгийн эхийг гүн
Жамъяанаар
зохиолгон Богд хаан
тамга даржээ



Богд хаан ЗОУ-аас
тусламж гуйсан бичгийн
монгол эхийн ноорог.
Уг бичиг УТА-г
хадгалагдаж байна.

387



Богд хаан тусламжийн бичигт тамга дарсанаар
ЗОУ-д одох 7 төлөөлөгчдөд

1. Тусгаар тогтнолоо сэргээх,
2. Дайн байлдаангүй, хэлэлцэн зөвших замаар
Монгол дахь хятад цэргийг хурдан татаж
буцаалгах чиглэл өгч

Монгол улсын нэрийн өмнөөс Орос улстай
хэлэлцээр хийх эрх олгожээ

Тусламжийн бичгийг хааны зарлигийг хүлээсэн
Д.Сүхбаатар, Д.Лосол, Д.Догсом нар авч мордов




<https://www.olloo.mn>

Д.Лосол, Д.Догсом нар



<https://www.sonin.mn>

Д.Сүхбаатар



Богд хаант Засгийн газар Орос улсаас цэрэг,
зэвсэг, санхүүгийн тусламж хүссэнгүй зөвхөн
дипломат дэмжлэг зөвөлгөөг эрсэн нугалбар
бичиг илгээжээ


Энэ хүсэлт бол Монгол төрийн бодлого, монгол
төрийн бодлогын уламжлал байсан юм

Богд хаан 7-н төлөөлөгчдөд
аравнайсан бурхан бүтээж
аян замын ерөөл тавьжээ

Богд хааны төлөөлөгчид гурав
хуваагдан эн тэргүүнд Данзан,
Чойбалсан нар, тэдний
хойноос Сүхбаатар, Лосол,
Догсом гурав хамгийн сүүлд
Бодоо, Чагдаржав нар хил
давж 1920 оны 8-р сарын
дундуур ЗОУ-ын Эрхүү хотод
уван цуван очиж нийлэв



<https://www.khutagtsan.mn>



Төлөөлөгчид Дээд Шивээнд ЗОУ-ын консул
О.И.Макстеник, Дээд-Үдэд ОК/б/Н-ын Төв
Хорооны Алс Дорнодын товчооны гишүүн
Б.З.Шумяцкий, Эрхүүд ЗОУ-ын Гадаад хэргийн
ардын комиссариатын төлөөлөгчийн орлогч
Ф.И.Гапон нартай тус тус уулзжээ.

Богдын тамгатай бичгийг Ф.И.Гапонд 1920 оны
8-р сарын 19-ний оройн 6 цагт гардуулав.

References

1. Монгол Ардын Үндэсний хувьсгалын анх үүсэж байгуулагдсан товч түүх, Чойбалсан Х, Лосол Д, Улсын хэвлэлийн газар, 1979
2. Монголд улс төрийн нам байгуулагдсан түүхийн судалгаа (1918-1921), Алтанбагана А, диссертаци, 2015
3. Монгол улсын түүх, МУИС Пресс хэвлэлийн газар, 2017
4. XX зууны Монголын түүхийг шинээр эргэн харахуй, Отгонжаргал С, Адмон хэвлэлийн газар, 2003

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА